

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Жамсрангийн Самбууний алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн оиг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, бүрэн эрхт элчин сайд, XX зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбууний мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жамсрангийн Самбууний мэндэлсний 130 жилийн оиг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/оиг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбууний эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

3/оиг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, ном туурвин хэвлүүлэх, баримтат кино бүтээх болон төлөвлөсөн холбогдох бусад арга хэмжээнд шаардлагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд судалж шийдвэрлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг